
ХОРШООХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН МЭДЭЭЛЭЛ

Сум хөгжүүлэх сан нь анх 2011 оноос эхлэн сумын жижиг, дунд, үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор хөнгөлөлттэй зээл олгож эхэлсэн.


Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны сайдын 2026 оны 05 сарын 07-ны өдрийн А/188 тоот тушаалаар шинэчлэгдэн батлагдсан “Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ар сан нь дараах нөхцөлтэй байна.




Сангаас 2021-2026 оны хугацаанд 57 иргэнд 392,212,684 төгрөгний 29 чиглэлийн төслийг санхүүжүүлж хөнгөлөлттэй зээл олгосон байна. Үйл ажиллагааны чиглэлээр авч үзвэл:

- ✓ Сүүний чиглэлийн үхрийн төсөл-6 иргэнд -35,0
- ✓ Мебель тавилга үйлдвэр-1 иргэн-3,0 сая
- ✓ Блок үйлдвэрлэл-1 иргэн-10,0 сая
- ✓ Гахай аж ахуй-1 иргэн-10,0
- ✓ Газар тариалан хүлэмжийн аж ахуй эрхлэх-1 иргэн-6,0 сая
- ✓ Оёдолын цех -6 иргэн-28,3 сая
- ✓ Цахилгаан бараа засвар -1 иргэн-2,2 сая
- ✓ Үсчин гоо сайхан- 2 иргэн-5,5 сая төг
- ✓ Гутал үйлдвэрлэл-2 иргэн-5,7 сая
- ✓ Цагаан гүү худалдан авах-2 иргэн-7,0 сая
- ✓ Хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээ-2 иргэн-34,0 сая
- ✓ Аялал жуулчлал-1 иргэн-3,0 сая
- ✓ Машин, мотоцикль завсар үйлчилгээ-2 иргэн-7,0 сая
- ✓ Сүү, цагаан идээ боловсруулах-7 иргэн-46,0 сая
- ✓ Мод, модон эдлэлийн цех-2 иргэн-9,0
- ✓ Түүхий эдийн худалдаа –2 иргэн 34 сая
- ✓ Сур, суран эдлэл, арьс нэхий боловсруулах-2 иргэн 6,0 сая
- ✓ Хүүхдийн тоглоом хувцас-1 иргэн -1,0 сая
- ✓ Нарийн боовны үйлдвэрлэл -1 иргэн-10,0 сая
- ✓ Зочид буудал, зоогийн газар-1 иргэн-8,0 сая

- ✓ Мал сүрэг эмчлэн эрүүлжүүлэх-1 иргэн-4,0 сая
- ✓ Гар утас, мотоцикль сэлбэг худалдаа-1 иргэн-12,0 сая
- ✓ Малын үүлдэр угсаа сайжруулах-2 иргэн-8,0 сая
- ✓ Шатахуун түгээх станцын үйл ажиллагаанд-1 иргэн-15,0 сая
- ✓ Эмийн сангийн үйл ажиллагаа-2 иргэн -25,0 сая
- ✓ Газар тариалан эрхлэх-1 иргэн -30,0 сая
- ✓ Дугуй засвар, гагнуур-1 иргэн-5,0 сая
- ✓ Төмөр хийц малын хашаа-1 иргэн-6,0 сая
- ✓ Хөргүүр, зоорь хүнсний худалдаа-1 иргэн-30,0 сая





2025 оны сарын 01 сарын 01-ны өдрийн байдлаар хоршоо хөгжүүлэх сан нь 95,8 сая төгрөгний үлдэгдэлтэй, зээлийн эргэлтэд 22 зээлдэгчийн 116,8 сая төгрөг, үүнээс нийт хугацаа хэтрэлт-37,9 сая төгрөг, үүнээс чанаргүй зээл 12-3 жилийн хугацаагаар хугацаа хэтэрсэн -24,5 сая төгрөг, явцын хугацаа хэтрэлт -13,4 сая төгрөг байсан бөгөөд нийт зээлийн 36,2 хувийг хугацаа хэтрэлт эзэлж байсан.

Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн бүртгэл, мэдээллийн ажлын сайжруулж 22 зээлдэгчийн төлөлтийн мэдээллийг 2022 оноос эхлүүлэн дансны хуулгаас түүж, эргэн төлөлт, мэдээллийг нэг бүрчлэн тулган шалгаж, зээлдэгч тус бүрээр

нарийвчилсан бүртгэл гаргаж, төсвийн ерөнхий ерөнхий нягтлан бодогчтой тооцоо нийлэн, хоршоо хөгжүүлэх сангийн системд 189,4 сая төгрөгний зээлийн хуваарь, бүртгэлийг хийж, сар бүр зээлийн төлөлт, хугацаа хэтрэлтийг дэлгэрэнгүй гаргаж сумын удирдлагуудыг мэдээллээр ханган ажиллаж, мөн Монгол банкны зээлийн мэдээллийн сангийн зөрчилтэй 15 иргэний 82,4 сая төгрөгний ангиллыг засварласан, зээлдэгч нарын гомдлыг шийдвэрлэсэн байна.

Хоршоо хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын хэрэгжилтийг хангах хүрээнд ИТХ-аар төсөл сонгон шалгаруулах хороо болон хоршоо сангийн хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүн шинэчлэн батлуулж, хурлын төлөөлөгч Г.Хишигжаргалаар даргатай хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүн төсөл хэрэгжүүлэгч нарын үйл ажиллагаа болон зээлийн зориулалт, эргэн төлөлтийг сайжруулах зорилгоор 3 удаагийн хяналт, шалгалт зохион байгуулж холбогдох мэдээ, мэдээллийг ИТХ, сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газарт нарт тайлагнаж, үр дүнг хэлэлцүүлсэн.

Дээрх хугацаанд 2013, 2015, 2018,2019, 2021 онууд олгосон 5 зээлдэгчийн 23,2 сая төгрөгний чанаргүй зээл, 2021 онд олгосон 4 зээлдэгчийн 5,4 сая төгрөгний найдвартай зээл, явцын хугацаа хэтрэлттэй 8 зээлдэгчийн 41,1 үлдэгдэлийг эргэн төлүүлж, 102,2 сая төгрөгийг төвлөрүүлж, 196,6 сая төгрөгний эх үүсвэр бүрдэж, чанаргүй зээлийн эх үүсвэрт эзлэх хувийн жин 25,3-0,6 хувьд болж, 24,7 хувиар бууруулан ажилласан байна.

Төсөл сонгон шалгаруулах хорооны хурлын товыг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар тогтоолгон 2026 оны 02 сарын 25-наас 03 сарын 25-ныг дуустал, мөн төсөл сонгон шалгаруулах хорооны 09 сарын 10-ны өдрийн хурлын шийдвэрээр 2026 оны 09 сарын 16-с 2026 оны 10 сарын 15-ны дуустал төсөл хүлээн авахаар тогтоож зар мэдээ, мэдээллийг хоршоо, жижиг дунд үйлдвэрлэл, аж ахуй эрхлэгчид хүргэн ажилласан.

_____oOo_____